


2. Зөвлөмж, гарын авлага

Бага ангийн бүлэг бүрийн номын санд каталоогоос ном захиалах заавар

Аймгийн төв ба сумын сургуулийн бага ангийн бүлэг бүрт зориулан Хүүхдийн номын каталогийг боловсруулсан ба каталоогоос бага ангийн багш нар номын захиалгаа хамтарч хийгээд, сургууль захиалгыг нь нэгтгэн БСШУСЯ-ны “Боловсролын салбарын мэдээллийн систем (БСМС)”-ээр дамжуулан онлайнаар ирүүлнэ.

БСМС ДЭЭРХ “НОМ ЗАХИАЛАХ МАЯГТ” ЦОНХНЫ ТАНИЛЦУУЛГА


<http://www.esis.edu.mn> сайтаар өөрийн сургуулийн эрхээр ороод Асуулгын удирдлага модулийн “Ном захиалах маягт” гэсэн цонхыг нээнэ.



НОМЫН ЗАХИАЛГА ХИЙХ ДАРААЛАЛ

1-Р АЛХАМ: КАТАЛОГООС НОМ СОНГОХ

“Ном захиалах маягт” хуудасны баруун дээд талын цонхноос **НОМЫН КАТАЛОГЫГ ТАТАЖ**, бага ангийн бүх багш нарт файл хэлбэрээр өгнө.



Багш нар ном бүрийн мэдээлэлтэй сайтар танилцаад, сонгосон номын дугаар болон нэрийг захиалга нэгтгэх хүнд бичиж өгнө.

2-Р АЛХАМ: БҮЛЭГ БҮРИЙН ЗАХИАЛАХ НОМЫГ НЭГТГЭХ

Сургууль нь захиалга нэгтгэх хүнийг томилж, цонхны баруун дээд талд байгаа **ЗАХИАЛГА НЭГТГЭХ ФАЙЛЫГ** татаж бүлэг бүрийн захиалсан номын тоог оруулна.



“Захиалга нэгтгэх файл”-ыг(excel) хэрхэн бөглөх вэ?

- ✓ Зааврыг уншина. I-V анги тус бүрээр нэрлэсэн хуудас бүр дээр зөвхөн шараар тодруулсан хэсэгт дараах байдлаар захиалгаа оруулна.
 - Номын дугаар гэсэн хэсэгт сонгосон номын 4 оронтой дугаарыг бичихэд номын нэр болон нэгжийн үнэ автоматаар гарч ирнэ.
 - Тухайн дугаартай номноос захиалах тоог бүлэг тус бүрээр оруулна.
 - Нэг бүлэг нэг номноос 5-с дээш ширхгийг захиалахгүй болохыг анхаарна уу.


Жишээ нь: I анги гэсэн хуудсанд **1002 дугаартай “Аавын тоглоом” нэртэй ном**, 1-р ангийн 7 бүлэг тус бүр 1-2 ширхэг захиалсан тоог оруулахад нийт тус ном 12 ширхэг 50,160 төгрөг гэж автоматаар бодогдоно.

Захиалга нэгтгэх хуудас				1-р анги															
Заавар: Доорх зааврын дагуу зөвхөн шараар тодруулсан нүдийг бөглөнө.																			
1. Бүлэг бүрийн багш нараас сонгосон номын дугаар ба нэрийг авна.																			
2. Номын дугаарыг шараар тодруулсан НОМЫН ДУГААР гэсэн баганад шивнэ.																			
3. Бүлэг тус бүрийн харгалзах нүдэнд захиалах тоо ширхэгийг оруулна. (1 бүлэг нэг номноос 5-с дээш тоогоор захиалахгүйг анхаараарай.)																			
4. Шараар тодруулсан хэсгийг бөглөж дуусахад бүлэг тус бүрийн захиалах номын тоо, үнэ баруун дээд талын хүснэгтэнд автоматаар бодогдоно.																			
				1-р ангийн захиалах номын нийт															
				Нийт бүлгийн тоо	7														
				Нийт номын тоо	12														
				Нийт номын үнэ	50,160														
#	Номын дугаар	Номын нэр	Номын нэгжийн үнэ	1-р ангийн бүлэг тус бүрийн захиалах номын тоо													Нийт номын тоо	Нийт үнэ	
				/Бүлгийн нэрийг өөрийн сургуулийн нэрлэдгээр засаж болно/															
10	1002	Аавын тоглоом	4,180	2	1	2	2	1	2	2								12	50,160

- ✓ Энэ маягаар анги бүрийн хуудсанд захиалгыг оруулж дуусахад “Сургуулийн нэгтгэл” гэсэн хуудсанд сургуулийн нийт захиалах номын тоо автоматаар нэгтгэгдсэн байна.
- ✓ СУРГУУЛИЙН НЭГТГЭЛ гэсэн хуудсанд БСМС-ийн “Ном захиалгын маягт” цонхонд өгөгдсөн танай сургуульд оноогдсон төсвөө хуулж шараар тодруулсан хэсэгт оруулна. Үүнийг харуулбал:

Сургуулийн нийт захиалгын дүн						
			Нийт санхүүжилтийн эрх (төгрөг)		16,758,000	
			Захиалсан номын нийт тоо		919	
			Захиалсан номын нийт үнэ (төгрөг)		16,599,660	
			Зөрүү (төгрөг)		158,340	
#	Номын дугаар	Номын нэр	Анги	Номын нэгжийн үнэ /төгрөгөөр/	Хэдэн хувь захиалах ширхэг	Нийт номын үнэ /төгрөгөөр/
10	1001	6-н настай хүүхдийн баруун тархийг хөгжүүлбэ	1	5,000	10	50,000
11	1002	Аавын тоглоом	1	4,180	12	50,160
12	1003	Алаг эрээн тахиа	1	18,000	13	234,000
13	1004	Алиман гүнж	1	3,000	19	57,000
14	1005	Алтан үст ба 3-н баавгай үелж унших ном	1	2,800	25	70,000
15	1006	Алтан үст охин ба гурван баавгай	1	5,900	15	88,500

3-Р АЛХАМ: “БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ”-ЫН НОМ ЗАХИАЛАХ МАЯГТАНД ЗАХИАЛГАА ШИВЭХ



БСМС-ын <http://www.esis.edu.mn> сайтын ”Ном захиалах маягт” цонхонд СУРГУУЛИЙН НЭГТГЭЛ хуудаснаас номын **ЗАХИАЛГЫН ТООГ** нэг бүрчлэн гараар шивж оруулна.

Ном захиалах маягт: (тоогоор)


Аймгийн тоо ба сумын сургуулийн бага ангийн номын санц каталогаас ном захиалах маягт

Хөлбөө барих хүч	Барилдаг
Утасны дугаар	99554411

Нийт санхүүжилтийн эрх (төггрөг)	16,758,000.00
Захиалсан номын нийт тоо	919
Захиалсан номын нийт үнэ (төггрөг)	16,599,660.00
Зөрүү ()	158,340.00

Нийт санхүүжилтийн эрх (төггрөг)	Төсөв 1-р анги	Төсөв 2-р анги	Төсөв 3-р анги	Төсөв 4-р анги	Төсөв 5-р анги
16,758,000.00	1,837,600.00	2,940,000.00	3,430,000.00	3,920,000.00	4,630,500.00

№	Номын дугаар	Номын нэр	Анг	Номын нэгжийн үнэ (төггрөгөөр)	Хэдэн хувь захиалжас (илэрсэл)	Дүн
1	1001	6-н настай хүүхдийн баруун тэрийг хөгжүүлэх	1	5,800.00	10	50,000.00
2	1002	Алман тоглоом	1	4,180.00	12	50,160.00
3	1003	Алаг эрэн талхи	1	18,000.00	13	234,000.00
4	1004	Алман гүжиг	1	3,800.00	19	57,000.00
5	1005	Алтан уст ба 3-н баагай үетэй унших ном	1	2,800.00	25	70,000.00
6	1006	Алтан уст охино ба гурван баагай	1	5,900.00	15	88,500.00

- ✓ **ХАДГАЛАХ** товчийг дарснаар нийлбэр дүн бодогдоно.
- ✓ Номын захиалгаа зөв оруулсан бол нийлбэр дүн болон зөрүү дүн СУРГУУЛИЙН НЭГТГЭЛ хуудасны дүнтэй тохирч байх ёстой.
- ✓ **ИЛГЭЭХ** товч дарснаар захиалга хийгдэнэ.
- ✓ Илгээсэний дараа  товч үүсэх засвар оруулах шаардлагатай үед ашиглана.

4-Р АЛХАМ: “ЗАХИАЛГА НЭГТГЭХ ФАЙЛ”-ЫГ (EXCEL) И-МЭЙЛЭЭР ЯВУУЛАХ

- ✓ “Боловсролын салбарын мэдээллийн систем”-д захиалгаа оруулахаас гадна "Номын захиалга нэгтгэх файл"-даа **нэр** өгөөд nom.2018sb@gmail.com хаяг руу и-мэйлээр илгээнэ.
Жишээ нь: Архангай_Хотонт гэж аймаг сум, сургуулийнхаа нэрээр нэрлэнэ.
- ✓ Захиалгаа 2018 оны 9-р сарын 28-ны дотор дээрх 2 хувилбараар илгээнэ.

АСУУЛТ БАЙВАЛ ХОЛБОГДОХ УТАС: 70001220 (ажлын цагаар) ГАР УТАС: 99055727